

## ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ДУНД НИЙГМИЙН НАРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БҮРЭЛДЭХ ҮЙЛ ЯВЦЫГ АРХЕОЛОГИЙН СУДАЛГААГААР ТОДРУУЛАХ НЬ

Б. Жаргалан<sup>1, \*</sup>, У. Гарднер<sup>2</sup>

**Товч агуулга:** Нүүдэлчдийн нийгэм нарийн зохион байгуулалттай байх асуудал онолын хүрээнд ямагт судлаачдын толгойг гашилгасаар ирсэн. Үүний гол шалтгаан нь нүүдэлчдийг маш хязгаарлагдмал үүднээс харж үздэгтэй холбоотой. Үүнээс гадна археологийн судалгаанд ашиглагддаг “нарийн зохион байгуулалт” хэмээх нэр томъёо хүртэл өөрөө олон асуудалтай юм. Анхандаа нарийн зохион байгуулалтын тодорхойлолтыг тогтолцооны тухай онолууд болон улс төрийн эдийн засаг дээр тулгуурлан боловсруулсан. Гэтэл энэ бүхний цаана нийгмийн анги давхаргатай, аж үйлдвэржсэн эдийн засагтай, төвлөрсөн засаглалтай суурин нийгмүүд байсан гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ өгүүлэлд бид нарийн зохион байгуулалтын сонгодог тодорхойлолтууд Евразийн тал нутгийн нүүдэлчдийн босгосон улс төрийн зохион байгуулалтыг шинжлэхэд тохиромжгүй гэж үзэж байгаа. Тийм учраас нэгдэл, цар хүрээ, нүүдлийн үйл явц дээр тулгуурлаж нарийн зохион байгуулалтыг томъёолох шинэ хандлагыг нэвтрүүлж байна. Энэхүү хандлагын тусламжтайгаар умард Монголын хоёр хөндийн биет өвийг илүү оновчтой тайлбарлах, цаашилвал НТӨ I мянганы төгсгөлд Хүннүгийн төр мандахад хүргэсэн дэд бүсийн зохион байгуулалтыг тайлбарлах боломж бүрдэж байгаа юм.

**Түлхүүр үг:** нүүдэлчдийн археологи, нарийн зохион байгуулалт, нийгмийн үйл явц

### Удиртгал

Нүүдэлчдийн нийгэмд нарийн зохион байгуулалт бий болох, хувиран өөрчлөгдөх асуудал руу орохоос өмнө “нарийн зохион байгуулалт” (social complexity) хэмээх нэр томъёоны асуудлыг хөндөх шаардлагатай юм. Нийгмийн шинжлэх ухааны судлаачдын дунд нарийн зохион байгуулалтыг нэгдмэл байдлаар тодорхойлсон зүйл өнөөг хүртэл алга. Гэсэн хэдий ч археологчид үеийн үед нийгмийн зохион байгуулалтын үйл явцыг судлахдаа “нарийн зохион байгуулалт” хэмээх нэр томъёог өөрийн судалгааны чиглүүлгээ болгосон хэвээр байна. Ийм тохиолдолд судалгааны үр дүн ихэнхдээ нарийн зохион байгуулалттай нийгэм ямар хэв шинжийг агуулсан байхыг тогтоосон, тодорхойлсон байдаг. Гэвч эдгээр ангилал, оноосон нэр нь олон төрлийн зохион байгуулалтыг хэрхэн бүрэлддэг болохыг оновчтой тайлбарлаж чадахгүй хэвээрээ л байна. Тиймээс нийгэм, улс төрийн нарийн зохион байгуулалтыг бүрдүүлж байсан хэв шинжүүдийг байсан, байгаагүй гэх зүйлд анхаарахаас илүүтэйгээр байсан хэв шинж, үйл явц хэрхэн явагдаж, юутай уялдаж тухайн нийгмийг нарийн зохион байгуулалттай болгож байсныг тайлбарлаж чадвал бид

археологиор дамжуулан хүн ба хүний нийгмийг илүү сайн ойлгох юм..

Энгийн хэлбэрээс илүү нарийн зохион байгуулалттай болох үйл явц төрөл бүрийн газар, цаг үед харилцан адилгүй хэв шинжтэй явагддаг болохыг судлаачид тогтоогоод байгаа юм. Нийгэмд аливаа зүйл шинээр бий болох, гаднаас орж ирэх тохиолдол бүрт тухайн нийгмийн хувьд цоо шинэ үзэгдэл, туршлага болж байдаг. Үүнийг дагаад тухайн нийгмээс урган гарах зүйлс хүртэл шинээр бий болно (нийгэм өөрийгөө илэрхийлэх арга барил, нийгмийн анги давхарга үүсэх гэх мэт). Нэгдэж томорч байсан нийгмүүдийн задрал хүртэл хамааралтай хүмүүст шинэ туршлага, үзэгдэл байсан байж таарна. Тиймээс нүүдэлчдийн нийгмийн хэв шинж ба үйл явцыг нарийн зохион байгуулалттай нийгмийн зүгээс судлан авч үзье гэвэл задрах болон нэгдэх үйл явцыг зайлшгүй хамруулан авч үзэх хэрэгтэй хэмээн судлаачид үздэг.

Сүүлийн үеийн археологийн судалгаагаар Дотоод Азийн нүүдэлчид тэдний сүлжээ байгуулах, ашиглах чадварыг баримтжуулсан байдаг. Энэхүү чадварын үндэс нь амьтанг уналганд ашиглах, нүүдэл суудлыг эрхэмлэсэн шинж чанар юм хэмээн үзжээ (Kradin 2006, 2018). Мөн үүн дээр нэмээд уудам орон зайд харилцааны энэхүү сүлжээг идэвхтэй, ашигтай байлгахын тулд орон нутгийн бүлгүүдийг нэгтгэх үйл явц идэвхтэй явагдаж байх байсан гэж үздэг (Gardner 2016; Honeychurch 2015). Хэрэв энэ үнэн бол анхны

<sup>1</sup> МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

\* Холбоо барих зохиогч: [jargalanb@num.edu.mn](mailto:jargalanb@num.edu.mn)

<https://orcid.org/0009-0004-3926-5644>

<sup>2</sup> Йелин Их Сургууль, АНУ

нэгдэх үйл явц жижиг бүлгүүд нийлж олон бүлгээс бүрдсэн нэг том бүлгийг үүсгэх дүртэй байх байсан. Энэ үйл явц яваандаа өргөжсөөр түрүү төмрийн үеийн (НТӨ I мянганы эхний хагас) бүлгийн холбоог үүсэх нөхцлийг бий болгосон байх учиртай. Монголын тал нутгийн анхны төрт улс болсон Хүннү (НТӨ III зуунаас НТӨ II зуун) бүрэлдэх үйл явц хүртэл энэхүү бүлгүүдийн холбооны зарчим дээр тулгуурласан юм. Энэхүү улс төрийн хөгжлийн үйл явц, замналыг олон монгол, орос болон барууны археологчид санал болгож байсан ч чухам хаана, ямар үйл явц өрнөж байсныг ямар эд мөрийн баримтаар хэрхэн тодруулах хандлага, арга зүй дутмаг хэвээр байна.

Үүнээс улбаалан нийгмийн нарийн зохион байгуулалтын судалгаа нь нийгмийн харилцаа, нийгмийн цар хүрээ, харилцааны сүлжээний хэр хэмжээнд илүү анхаарал хандуулахад хүргэж байна. Иймээс орон нутгийн зохион байгуулалт өмнө дурдсан үйл явцын дагуу бүрэлдсэн эсэхийг археологийн үүднээс шалгахын тулд умард Монголын зэргэлдээ хоёр хөндийн нийгмийн үйл явцыг НТӨ II мянганы төгсгөлөөс НТӨ I мянганы эхэн үеийн хүрээнд тодруулах шаардлага урган гарсан билээ. Үүнээс гадна орон нутгийн болон дэд бүсүүдэд буй бүлгүүдийн харилцааны чанарт том нөлөө үзүүлсэн зүйл бол адууг уналганд ашиглах явдал ба үүнтэй холбоотой технологийн өөрчлөлтүүд юм гэж үзэж байгаа.

Дээрх асуудалтай холбоотой таамгуудыг Эгийн голын хөндийд хийсэн археологийн судалгаа явагдаж байх үеэс л хэлэлцэгдэж байсан юм (Honeychurch et al. 2009). Энд байх чулуун байгууламж, булш, сууцны судалгаанаас харахад НТӨ I мянганы эхэн үеэс дунд үе хүртэлх хугацаанд нэгдэх үйл явцыг идэвхтэй өрнөж байсан гэсэн урьдчилсан байдлаар дүгнэсэн байдаг. Үүнээс улбаалан зэргэлдээ хөндийн бүлгүүдийг нэгтгэсний үр дүнд Эгийн гол нь дэд бүсүүдийн төв шинжтэй болж, өмнө нь байгаагүй орон зай, хүн амыг хамарсан шинэ төрлийн харилцааны хэлбэр урган гарчээ.

Эдгээр өөрчлөлтийг эхлэхэд хоёр хүчин зүйл голлох үүрэг гүйцэтгэсэн байна. Нэг нь адууг уналганд ашиглах болсноор илүү өргөн цар хүрээ бүхий харилцаа үүсэх боломж, нөгөө нь бүлэг хоорондын холбоо юм. Уг холбоо анхандаа удирдагч, захирагчийн тушаал, бодлогоор бус харин олон нийтийн буюу бүлгийн ашиг сонирхол дээр тулгуурлан үүссэн байх тун боломжтой юм. Тухайн холбооны нэг хэсэг байснаар шинэ мэдээлэл, мэдлэг олж авах, мал амьтны солилцоо өрнүүлэх, мал аж ахуйтай холбоотой дэмжлэг авах, зан үйлийн арга хэмжээнд оролцох боломж бүрдсэн байх учиртай. Холбоон дээр суурилсан энэхүү зөвшилцлийн хэлбэр нь эргэн тойрны бүлгүүдийг Эгийн гол дээр суурилан

соёлын, ахуйн, улс төрийн, нийгмийн хувьд төвлөрөх хөдөлгөөнийг идэвхжүүлж, яваандаа түрүү төмрийн үе гэхэд орон нутгийн анги давхарга, захирагч төрөн гарахад хүргэсэн байж болох юм. Хэрэв ийм үйл явц өрнөсөн бол археологийн судалгаагаар энэ бүхнийг харуулах эд мөрийн баримт буюу биет илрэлийг олох учиртай билээ.

Юуны өмнө Эгийн голын хөндийг тойрон байрших бусад хөндийн эдийн соёл, туршлагын ямар нэгэн хэлбэр төв хөндийгөөс илрэх ёстой. Учир нь нэгдэх замаар дэд бүсийн холбоонд хамрагдсан бусад хөндийн бүлгүүд төв газарт зохион байгуулагдсан олон арга хэмжээнд оролцож өмнө нь дурдсан боломжуудыг бий болгоно. Гэхдээ ийм үйл ажиллагаанд оролцохдоо өөрсдийн хөндийн эд зүйл, эсвэл онцлогоо харуулах туршлагыг авчирсан байх учиртай. Эгийн голыг дэд бүсүүдийн төв болсон гэдгийг батлах хоёр дахь үндсэн таамаглал бол төв газрын хэв шинж зөвхөн эндээс л олдох учиртай хэмээн үзэж байгаа билээ.

Эгийн голын хөндийн хойд, баруун хойд хэсэгт орших Тарвагатайн голын хөндийд сүүлийн хэдэн жил хийсэн археологийн судалгаа (Burentogtokh 2017; Gardner 2016) дээрх дэвшүүлэн буй асуултын хариуг олох, турших боломжийг олгож байгаа юм.

Асуудал руу нарийн орохоос өмнө эхлээд эдгээр газрын археологийн судалгааны байдлыг товч танилцуулья. Дараа нь Эгийн гол, Тарвагатайн голын (Зураг 1) эдийн соёл цаг хугацааны турш хэрхэн өөрчлөгдсөн болохыг тодруулах, энэхүү өөрчлөлт санал болгож буй бидний нэгдэл ба нарийн зохион байгуулалтын замналтай хэрхэн нийцэж байгааг шинжлэх болно.

### Бүс нутгийн байдал

НТӨ II мянганы төгсгөлд Монголын газар нутагт соёлын өөрчлөлт идэвхтэй явагдаж байсан гэж үзэж болно. Өгүүлэн буй цаг хугацааг хожуу хүрэл зэвсэг (НТӨ 1400–1000 он), төмрийн түрүү үе (НТӨ 1000/900–300 он) хэмээн нэрлэнэ. Энэ үед таван хошуу мал бүхий аж ахуй Монголын баруун хойд хэсэгт эрчимтэй хөгжиж байсныг тухайн үеийн хүмүүсийн сүүний хэрэглээнээс (Orlando 2018) харж болох бөгөөд мал аж ахуйн энэхүү хэлбэр бусад тал нутгаар мөн тархсан байх боломжтой хэмээн судлаачид үзэж байгаа билээ. Ингэснээр нүүдлийн мал аж ахуй уламжлалт ан, түүвэр, загасчлах аж ахуйг орлох болжээ. Харин үр тариа тариалж байсан ул мөр харьцангуй хожим буюу НТӨ 300/200 оны үед холбогдоно. Энэ нь тухайн цаг үед нүүдлийн мал аж ахуйн туршлага, мэдлэг, арга ухаанд түлхүү анхаарч байсан гэдгийг харуулж байна (Chang 2018; Honeychurch 2015). Нүүдлийн мал аж ахуйтай холбоотой хамгийн эртний он цаг бүхий бүрэн зөөврийн сууцны ул мөр түрүү төмрийн үед

хамаарагдаж байна (Gardner, Burentogtokh 2018).

Өгүүлэн буй цаг үед Монголын тал нутгаар өрнөж байсан өөр нэгэн үйл явц бол төрөл бүрийн чулуун байгууламж барьж, ашиглаж байсан явдал юм. Хожуу хүрлийн үед хиргисүүр хэмээх байгууламжуудыг төрөл бүрийн хэмжээ, загвартайгаар барьж байжээ. Хиргисүүрийг барих, ашиглах туршлагыг дэлгэрэнгүйгээр удахгүй танилцуулна. Хиргисүүртэй нягт холбоотой өөр нэгэн байгууламж бол буган хөшөө юм. Эдгээр хоёр байгууламжийн харилцан хамаарал ба холбоог олж тодруулах асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэдий ч НТӨ 1250/1200 оны үе гэхэд гол төлөв адууг хамруулсан тахилга үйлдэх зан заншил тал нутгийн нийгмүүдэд эрчимтэй тархах, үйлдэх болсон нь тодорхой байна. Хиргисүүр ба буган хөшөөг тойрон барьсан дугуй дагуул байгууламжуудаас олдох адууны толгойн ясны шинжилгээнээс харвал адууг ачлага, уналганд хэрэглэж байсан байх тун боломжтой юм (Taylor 2017).

Харин тухайн үед Монголын зүүн өмнөд болон төв өмнөд хэсгээр өөр төрлийн чулуун байгууламж байгуулах заншил давамгайлж байжээ. Хүнийг тэнгэр байдалтай нүүрээр нь доош харуулан оршуулсан булшийг (НТӨ 1500/1400 – 1000 он) эдүгээ шоргоолжин, хэлбэрт, Улаанзуух, Тэвш, түрүүлгэ нь харуулсан гэх олон янзаар нэрлэж байгаа ч нас барсан хүнийг байрлуулсан байдал, олон төрлийн мал дагалдуулж тавьдаг заншил нь тухайн үеийн мал аж ахуй эрхлэгч бүлгүүдийг хоорондоо харилцан уялдаатай байсныг харуулж байна. Харин дагалдуулж тавьсан олдворуудын хувьд хоорондоо харилцан адилгүй байх нь элбэг ажээ. НТӨ 1000 оны үед энэ оршуулгын заншил байр сууриа Монголын дорно талаас эхлэлээ тавьж аажимдаа төв, төр баруун хэсэг рүү цөмрөн орж ирсэн дөрвөлжин булшны оршуулгын заншил (НТӨ 1000 – 300 он) давамгайлах болсон юм. Энэ хоёр төрлийн булшнаас дөрвөлжин булш харьцангуй өргөн цар хүрээтэй судлагдаад байгаа бөгөөд ялангуяа түүний үүсэл гарал, барих болсон уламжлал нь нүүдэлчдийн дунд нийгмийн анги давхарга үүсч оршуулгын зан үйлээр дамжуулан нийгмийн байр суурийг илэрхийлэх ашиг сонирхолтой холбоотой гэж үзэж байгаа юм. Хэдийгээр тухайн үеийн нүүдэлчдийн харилцааны цар хүрээ, ахуйн амьдралын тухай мэдлэг тун дутмаг байгаа ч сүүлийн үед чамлахааргүй амжилтанд хүрээд байгаа эртний нүүдэлчдийн сууцны судалгаанаас үзвэл хожуу хүрэл зэвсгийн үед улирлын шинж чанартай нүүдлийн мал аж ахуй тал нутгийн хүмүүсийн үндсэн амьдралын хэв маяг болсон гэдгийг нотлоод байгаа билээ (Burentogtokh 2017).

Тэгвэл Монгол хожуу хүрэл ба түрүү төмрийн үеийн байдлыг бүс нутгийн хэмжээнд авч үзвэл


маш ерөнхий бөгөөд тодорхой байдал ажиглагдана. Хэдийгээр газар бүрт өөрийн гэсэн орчиндоо зохицсон, хоорондоо адилгүй мал аж ахуйн хэлбэр суурьшин тогтож байсан боловч ёслолын, оршуулгын, чулуун байгууламж барих ба ашиглах заншлын хоёр үндсэн хэлбэр Монголын баруун төв ба зүүн өмнөд хэсэгт бүрэлдэж байсан юм. Үүний нэг нь хиргисүүр, буган хөшөөгөөр илэрхийлэгдэх баруун, баруун төв хэсэг, нөгөө нь түрүүлгэ нь харуулсан ба дөрвөлжин булшаар илэрхийлэгдэх зүүн, зүүн өмнөд хэсэг билээ. Цаг хугацааны турш эдгээр булш оршуулгын хэлбэр болон заншлууд харилцааны идэвхжилтээр дамжин давхцах болсон байна. Тухайн үеийн бүрэлдэн буй бүлгүүдийн холбооны сүлжээ, адууны уналгаас болж идэвхжсэн нүүдлийн давтамж ба зай, тал нутгийн туршлагыг эрэлхийлсэн гадны сонирхол бүгд нийлж энэ бүхний үндсийг тавьсан байх учиртай билээ.

Эдгээр хоёр заншил давхцаж байсан хэсэг бол Монголын төв хэсэг. Гиймээс орон зай болон цаг хугацааны хувьд нийгмийн өөрчлөлт хэрхэн явагдсан болохыг археологийн үүднээс тодруулахад энэ бүс нутаг хамгийн зохистой газар юм. Чухамхүү энэ шалтгааны улмаас Эгийн гол ба Тарвагатайн голын судалгааг нэгтгэн шинжлэх зорилго үүссэн төдийгүй анхны үр дүнгээ өгч эхлээд байна.

### Хоёр хөндийн “тууж”

Эг-Сэлэнгийн бэлчирээс дээш 40 орчим км зайнд үргэлжлэх уул, хөндий, салаа голуудыг хамруулах газрыг Эгийн голын хөндий гэж нэрлэдэг. Хөндийн чанх хойд талд Бүтээлийн нуруугаас эх авч баруун зүгт урсах Тарвагатайн голын хөндий бий. Энэ гол Эгийн голын нэгэн адил хэд хэдэн салаа голтой. Аль аль нь “өөрийн” гэсэн тусдаа голын хөндий бүхий тусгаарлагдсан орчинтой. Нүүдлийн мал аж ахуйн бэлчээрийн нөөц ба хүрээлэн буй орчны хувьд энэ хоёр хөндий хоорондоо маш төстэй. Өөрөөр хэлбэл аль аль нь орон нутгийн төв болох боломжтой газар юм.

Хоёр хөндийн чиглэл хоорондоо адилгүй учраас зүүн тийш явах тусам Хантайн нуруугаар улам их зааглагдана. Хэрэв эдгээр хоёр хөндийн хооронд явах шаардлага гарвал далайн түвшнээс дээш 2100 метр өндөр нурууг давах хэрэгтэй байдаг. Тухайн нутгийхны мэдэх цорын ганц даваа нь Тарвагатайн голын хөндийн дунд хэсгийг Эгийн голын хөндийн баруун хойд хэсэгтэй холбодог Уургын даваа юм. Нийт даваа давах жимийн нийт урт 22 км. Уургын даваанаас гадна Хантайн нурууг давах өөр хэсгүүд байх боломжтой ч зам урт, өгсөх, уруудах өнцгөөрөө хамаагүй хүндрэлтэй аж. Мэдээж зорчих боломжтой өөр нэг зам бол Эгийн голыг өвлийн улиралд гатлах явдал юм.



Зураг 1. Өгүүлэлд дурдагдаж буй газрууд. Уургын давааг хар өнгийн зураасаар тэмдэглэв.

Нэг талаас харвал энэ хоёр хөндий хоорондоо маш тусгаарлагдсан юм шиг атлаа даваагаар дамжин хөндий хооронд зорчдог байсан туршлага хэдхэн арван жилийн өмнө үргэлжилж байжээ (Burentogtokh 2017). Тиймээс эдгээр хоёр хөндийн түүхэн хүн ам хоорондоо ойрхон, идэвхтэй харилцаатай байх нь тухайн нийгмийн сонголт байсан гэж үзэж болно. Археологийн нарийвчилсан хайгуулыг хоёр хөндийд хийснээс гадна өмнө дурдсан Уургын давааны жимийн дагуу мөн хийсэн юм. Ингэснээр бид хоёр хөндий болон тэднийг холбож байсан байх боломжтой даваа жим дагуу дурсгалт газрын төрөл, тоо ширхэг, газрын онцлогийн талаар арвин мэдээллийн санг бүрдүүлсэн гэсэн үг юм.

#### **Анхны чулуун байгууламжууд (НТӨ 1400-1200 он)**

Бид нийгмийн өөрчлөлтийн үйл явцын шинжилгээг хиргисүүрийн судалгаанаас эхлүүлж байна. Хоёр хөндийн хувьд чулуун байгууламж барих болсон хамгийн эртний он цаг Эгийн голын хөндийгөөс илэрсэн юм. Тэндэхийн хиргисүүрээс илэрсэн хоёр хүний ясанд хийсэн он цаг НТӨ 1378 ± 42 он, НТӨ 1213 ± 56 он гэж гарсан нь тухайн дурсгалын ерөнхий он цагийн хүрээнд багтаж байна.

Гэвч хиргисүүр бүхэн оршуулгын зориулалтаар

баригддаггүй болохыг оршуулгын ул мөргүй хиргисүүрийн малтлага харуулсан. Эгийн голын оршуулгаас тодруулсан он цагаас өмнө хиргисүүртэй төстэй овоолго чулуу бүхий оршуулгуудыг Монголын баруун хязгаар нутгаар барьж байсан нь Сагсай булшны хэлбэр юм (ойролцоогоор НТӨ 1500 оноос). Хиргисүүртэй харьцуулахад Сагсай булшнууд дагуул байгууламжгүй. Овоолго чулуу бүхий байгууламж барих заншил баруун зүгээс Монголын төв хэсэг рүү тархаж байхдаа хэлбэр, хэмжээ өөрчлөгдсөөр орж ирсэн байх боломжтой. Өгүүлэн буй хоёр хөндийд хиргисүүр хэлбэрээр чулуун байгууламжийн заншил НТӨ 1400- 1300 оны хооронд орж ирсэн болохыг он цагийн шинжилгээ харуулж байна.

Хиргисүүрийг барьж, ашиглаж байсан байдлыг авч үзвэл нэг айлаас хэтэрсэн хэмжээний зохион байгуулалт, хүч хөдөлмөр шаардагдаж байгаа нь тодорхой. Үүнээс гадна хиргисүүрүүдийг барьсан байршил, үзэгдэх орчин, нягтрал зэргийг хүрээлэн буй орчин, газрын онцлог, бэлчээрийн нөөцтэй харьцуулан авч үзвэл тодорхой тогтсон ойлголтын дагуу барьдаг болохыг тодруулсан (Жаргалан 2022). Хүнийг хиргисүүрт харьцангуй өндөр давтамжтайгаар оршуулдаг байсан ул мөр Хөвсгөл аймгаас (Littleton et al. 2012) олдсон нь чулуун байгууламжийн тухай ойлголт харилцааны идэвхжилтээр тархаж байхдаа олон янзын хэлбэр, хэмжээ, зориулалтыг олж

байсныг харуулж байна. Ийнхүү нэгэн хэлбэрийн эдийн соёл, заншлын хэлбэр олон газарт харьцангуй адилгүй байдлаар тусгалаа олсон нь нэг овог, аймгийн нүүдлийн үр дүн юм уу яг тодорхой бүтэцтэй нэгэн том соёлын хүрээ гэхээс илүү хүмүүсийн харилцааны үр дүнд соёлын уусгал, хүлээн зөвшөөрөлт, өөрчлөлтийн илэрхийлэл байжээ.

Хоёр хөндийд хиргисүүр барих болсон заншил яг ямар байдлаар эхэлсэн нь тодорхойгүй. Гэхдээ хоёр хөндийгөөс хоёр төрлийн тогтолцоо байгаа нь тод илэрсэн юм. Нэгдүгээрт, Хантайн нурууны хоёр талын үндсэн хөндий ба салаа амуудад байх хиргисүүрийн байршил, нягтрал хоёр тогтмол байна. Энэ нь аль аль хөндийд барьж, ашиглаж байсан хиргисүүрийн зориулалт, утга учир нь адилхан байсныг илтгэж байна. Хоёрдугаарт, маш том хэмжээний хиргисүүрүүд аль аль хөндийд маш цөөн тоотой олдсон. Эгийн голын хамгийн том хиргисүүр хөндийн баруун хойд хэсэгт, Тарвагатайн хамгийн том хиргисүүр хөндийн төв буюу дунд хэсэгт байрших ажээ. Эгийн голын хөндийн хувьд энэ газар бол гурван том замын их уулзвар газар юм. Нэг зам нь Эгийн голын хойд талд голоо даган явсан зам, хоёр дахь зам нь Эгийн гол руу баруун талаас Хатгачийн амнаас орж ирж байгаа зам, гурав дахь нь Тарвагатайн хөндийтэй холбогдох Уургын даваанаас орж ирж байгаа зам юм. Тарвагатайн голын хөндийн хувьд хамгийн том хэмжээтэй хиргисүүрүүдийг мөн л гурван их замын уулзвар дээр барьжээ. Нэг зам нь Тарвагатайг хойд талаар даган явах зам, хоёр дахь нь Тарвагатай руу хойд талаас орж ирэх Хужирт голыг даган орж ирэх зам, гурав дахь нь Уургын даваанаас бууж ирэх зам тус тус болно.

Үлэмж хэмжээтэй хиргисүүрүүдэд хийсэн он цагийн шинжилгээнээс харвал эдгээр их уулзварууд дээр хамгийн том төдийгүй хамгийн анхны хиргисүүрүүдийг барьсан болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл ойролцоогоор НТӨ 1400 он гэхэд хиргисүүр барих, ашиглах ойлголт хоёр хөндийд орж ирж аажимдаа орон нутгийн бүлгүүдийн дунд тархах болсон байна. Хэдийгээр хоёр хөндийн хүн ам өдөр тутмын давтамжтайгаар уулзаад байгаагүй хэдий ч Уургын давааны хоёр талын он цаг болон хэв шинж харьцангуй адилхан байгаа нь тухайн үеийн хөндий хоорондын харилцаа тогтмол явагдаж байсныг илтгэж байна. Нэг ёсондоо энэ үед хоёр хөндийн төв газар хаана байсан болохыг бид олж тогтоолоо гэсэн үг. Дараагийн хэдэн зууны турш энэ дэд бүсийн төв газар хэрхэн өөрчлөгдсөнөөс хамаараад бид харилцааны сүлжээ, нийгмийн нэгдэлт зэргийг арай өргөн хүрээнд тодруулах боломжтой болох юм.

## Чулуун байгууламжийн дараагийн үе шат (НТӨ 1200 – 750 он)

Үлэмж чулуун байгууламж барих заншил хоёр хөндийд нэвтэрсний дараагаар эдгээр байгууламжууд дээр төвлөрсөн зан заншлын шинэ хэлбэрүүд алхам алхамаар нэгэн зэрэг нэвтрэх болсныг бид дараагийн үе шатны ул мөрөөс харж болно. Энэ зан заншлын агуулга нь адуу хойлоглож толгой, хүзүү, хөл, туурай зэргийг өөрсдийн байгуулсан дагуул байгууламжинд тавих алхамуудаас бүрдэнэ. Одоогоор илрүүлсэн адууны ясанд хийсэн он цагийн шинжилгээнээс үзвэл энэ заншил Эгийн голын хөндийн баруун хойд хэсэгт байгаа хамгийн том хиргисүүрээс эхэлжээ (НТӨ 1127 ± 56 он). Үүний дараагийн он цагууд хөндийн доод хэсэг болон салаа амуудад барьсан хиргисүүрүүдээс гарсан юм. Харин Тарвагатайн голын хөндийн хамгийн эртний он цагтай дагуул НТӨ 965 ± 31 он гэж гарсан нь тухайн заншил Эгийн голд эхлээд бүрэлдэж дараа нь зэргэлдээ хөндий рүү нэвтэрсэн болохыг харуулж байна. Тарвагатайгаас гарсан хамгийн эртний он цаг мөн л хамгийн том буюу Уургын давааны харалдаа баригдсан хиргисүүрээс гарсан юм. Дараагийн эртний он цаг хэмжээгээрээ дөрөв дэх том хиргисүүрээс гарсан билээ. Тарвагатайн голын хөндийн хиргисүүрийн дагуул байгууламжийн нийт тодорхой он цагаас авч үзвэл хоёр зууны турш энэ заншил үргэлжилжээ. Үүнээс гадна хамгийн том хиргисүүр дээр энэ заншил олон удаагийн давтамжтайгаар дор хаяж 120 орчим жилийн турш давтагдсан байжээ. Мөн зарим нэг адууны толгойн яснаас ногт хэрэглэж байсан байх боломжтой ул мөр илэрсэн билээ.

Эдгээр баримтуудаас харвал Эгийн голд эхлэн орж ирсэн заншил Тарвагатайн голын хөндийн хүн амын дунд аажмаар дэлгэрэхдээ хамгийн том хиргисүүрээс эхэлсэн хэмээн үзэж болно. Зан зашил үйлдэх тухай ойлголт хүмүүс бие биеэндээ зочлох, ямар нэгэн үйл ажиллагаанд хамтран оролцох үед өргөжин тэлж байсан бололтой.

Мөн хөндий хоорондын ба бүлэг хоорондын харилцааны байдал хэр идэвхтэй байсан гэдгийг олж тогтоох үүднээс Тарвагатайгаас илэрсэн адууны шүдэнд хүчилтөрөгчийн изотопын судалгаа хийсэн юм. Адуу амьдралынхаа турш ямар төрлийн усны эх үүсвэрээс ундаалж байснаас хамаараад хүчилтөрөгчийн изотопын хэмжээ харилцан адилгүй илэрдэг. Ингээд тогтоол ба урсгал усны алийг нь ууж байсныг тодруулахад шинжилгээнд хамрагдсан зургаан адууны усны эх үүсвэр байнга өөрчлөгдөж байсныг харуулсан юм. Өгүүлэн буй дэд бүс нутагт байнгын тогтоол усны нөөцтэй Харгал, Айрхан зэрэг хэд хэдэн нуур байх боловч бүгд 60 км болон түүнээс хол зайнд байрлана. Энэхүү байдал нь эдгээр адууг

тууж юмуу унаж яваа хүмүүс дор хаяж хэдэн арван киллометрийн радиуст тогтмол эргэлдэж идэвхтэй харилцаанд ордог байсан болохыг харуулж байна (Жаргалан 2022).

Хоёр хөндийн дараагийн том үйл явдал НТӨ 900 оны үеэс эхэлжээ. Дөрвөлжин булш барих болсноор чулуун байгууламж барих, ашиглах заншил өөрчлөгдсөн юм. Хамгийн эртний он цагтай (НТӨ 871 ± 41 он, НТӨ 868 ± 28 он) буюу анхны хоёр дөрвөлжин булшийг Эгийн голын хөндийн зүүн өмнөд хэсгийн Баянголын аманд байгуулсан байна. Өөрөөр хэлбэл дөрвөлжин булш байгуулах заншил Эгийн голын хамгийн эртний, хамгийн том хиргисүүрээс хамгийн хол байж болох газарт байгаа дүр зураг харагдаж байна. Эдгээр хоёр булшнаас гадна 11 өөр дөрвөлжин булшинд он цагийн судалгаа хийхэд аажимдаа баруун хойд зүгт буюу гол өөд тархсан байна.

Хиргисүүрийн тархалттай харьцуулвал дөрвөлжин булшны тархалт Эгийн голын зөвхөн зүүн өмнөд ба төв хэсгээр хязгаарлагдаж байна. Харин Эгийн голын хиргисүүрийн төв болсон баруун хойд хэсэгт нийт 90 дурсгалын 3 нь дөрвөлжин булш байгаа бол Тарвагатайн голын хөндийд хийсэн олон жилийн явган хайгуулаар нэг ч дөрвөлжин булш олоогүй байгаа нь тун сонирхолтой. Энэ байдлыг шинжлэн дүгнэвэл НТӨ I мянганы эхэн үеэс дунд үеийн хооронд Эгийн гол ба Тарвагатайн голын хөндийн харилцаа болон тэдний байр суурь огцом өөрчлөгдсөн болох нь тод харагдаж байна. Хожуу хүрэл зэвсгийн үед хоёр хөндийн хүн ам тогтмол харилцааны үр дүнд нэгэн хэвийн чулуун байгууламж барих, ашиглах уламжлалыг бүрдүүлж олон жилийн турш хэрэгжүүлж байсан бол нөхцөл байдал НТӨ 900 он гэхэд өөр болж эхэлжээ. Дөрвөлжин булш барих, ашиглах явдал Эгийн голын хөндийн зүүн өмнөд хэсгээс эхэлсэн гэж өмнө нь дурдсан. Гэтэл Эгийн голын баруун хойд хэсэг болон Тарвагатайн голын хөндийн хүмүүс дөрвөлжин булшны уламжлалыг эхлүүлсэн хүмүүстэй харилцсаар байх ашиг сонирхолтой байсан төдийгүй шинээр бүрдэж буй нийгмийн харилцааны нэг хэсэг нь болох хүсэлтэй байсан байх тун боломжтой юм. Учир нь Эгийн голын хөндийн зүүн өмнөд хэсэгт хэдийгээр дөрвөлжин булшны соёл нэвтрээд даруй хоёр зуун болоод байсан ч хиргисүүрийн эргэн тойронд адуу тахилга болгон өргөж уламжлалт зан заншлыг явуулсаар байсан. Эндээс тогтоогдсон хамгийн хожуу он цагтай хиргисүүрийн дагуул байгууламжийг НТӨ 735 ± 56 оны үед барьсан. Харин үүнээс хойших үеийн адууны тахилга дан дөрвөлжин булшинд л үзэгдэх болсон. Энэ динамик орчинд Эгийн голын зүүн өмнөд хэсэг хуучин ба шинэ заншлыг тодорхой хугацаанд хослуулсан төв газар болж байсан төдийгүй цаашдын дэд бүсийн төв чухам хаана байх үндсийг тавьсан байна.

Дэд бүсийн хэмжээнд төв газар бий болох явдал чулуун байгууламжаас гадна өөр нэгэн археологийн дурсгалын судалгаагаар мөн тод харагдах болсон юм. Энэ бол Монголын тал нутгийн нүүдэлчдийн археологийн судалгаанд “шинээр” орж ирж байгаа сууц, суурингийн судалгаа юм. Шинэ гэсэн тодотгол нь нүүдэлчдийн булш, тахилгын байгууламж, урбанизм буюу хотын археологитой харьцуулбал хэдэн арван жилээс явуулж буй судалгааны чиглэл юм. Нэгэн үед нүүдэлчдийн байтугай дэлхийн археологид олж илрүүлэх ямар ч боломжгүй гэж тооцогдож байсан нүүдэлчин ард түмний сууцыг олон шатлалт хайгуул ба туршилтын үр дүнд олж илрүүлэх боломжтой гэдгийг нотлоод байгаа билээ (Жаргалан 2022). Ингэснээр археологид зөвхөн оршуулга, тахилгаас бүрдсэн “ёслолын” ертөнцөөс гадна нүүдэлчдийн өдөр тутмын, аж ахуйн ертөнцийн талаарх баялаг ойлголттой болох юм. Учир нь ёслолын үйл явдал өдөр тутмын хэмжээнд болдоггүйгээс гадна тухайн газрын хүн ам, аж ахуй, эдийн соёл, мэдлэг, туршлага, эдийн засаг, нийгмийн зохион байгуулалт зэргийг бүрэн тольдож чаддаггүй. Өөрөөр хэлбэл булш, тахилгын байгууламжаас олдсон зүйл болгоныг шууд тухайн хүмүүстэй хамааруулах нь эрсдэлтэй алхам билээ. Гагцхүү сууцны археологиос олдсон ахуйн холбогдолтой эд мөрийн баримтыг шинжилснээр бид үйлдвэрлэл, технологи, сүргийн бүтэц, газар тариалан зэрэг ойлголтуудыг бодитоор гаргаж тавина.

Өгүүлэн буй Эгийн голын хөндийн зүүн өмнөд хэсгийн хувьд үйл ажиллагааны төв болж байсныг илтгэх суурин олон тооны баганы ул мөр, хэд хэдэн барилгаас бүрдэнэ. Зарим нэг хэсэгт үзүүрлэсэн бугын эвэр гэх мэт ёслолын ул мөр гэмээр зүйлс мөн олдсон (Галдан 2015). Эндээс авсан он цагийн дээжний шинжилгээ тус сууринг НТӨ I мянганы дунд үед хамааруулж байна. Хоёр хөндийн хувьд энэ дурсгалт газар бол цоо шинэ төрлийн үзэгдэл байсан төдийгүй Эгийн голын хөндийн зүүн өмнөд талын бүлгийн шинээр олж авсан нэр хүндийн илрэл гэж үзэж байна.

Чулуун байгууламж барих, ашиглах явдал нэг орон зайд хоёр зуу гаруй жилийн давхцан явагдсаныг хөндий хоорондын нэгдэх үйл явцын ул мөр байж болох тухай дурдсан. Тэгвэл сууцны археологиос энэхүү саналыг дэмжих эд мөрийн баримт маш тодорхой байдлаар Тарвагатайн голын хөндийгөөс олдсон юм. Тэнд явуулсан олон жилийн явган хайгуул ба туршилтын малтлагын үр дүнд эрт цагийн нүүдэлчдийн сууцны ул мөрийг илрүүлээд байгаа билээ. Нэгдэх үйл явцтай холбоотой сууцыг Эг-Тарвагатайн бэлчирээс хойш холгүйхэн байх Төмрөн голын хөндийгөөс илрүүлсэн юм (TAS-77). Эдүгээ нутгийнхан өвөлжөөний зориулалтаар ашигладаг тус аманд өнгөн хөрснөөс доош хүний үйл ажиллагааг илэрхийлэх ямар нэгэн олдворын (яс, ваар гэх мэт) тархалт байгаа эсэхийг

шалгах явцад маш тодорхой хэмжээ, хэв шинжтэй галын ором олдсон билээ. Улмаар нарийвчилсан малтлага хийхэд сууцны хэлбэр, хэмжээ нүдэнд тодорхой харагдаагүй ч ясны хугархай, ваарны хагархай гэх мэт жижиг одвор болгоны байрлалыг гурван хэмжээст орон зайд бүртгэн авч шинжлэхэд тус сууц нь галын ормоос 2,5 – 3 метрийн радиустай, дугуй хэлбэртэй, өмнө зүгт харсан үүдтэй болох нь тогтоогдсон юм (Жаргалан, Гарднер 2018: 155-166). Эндээс ямар нэгэн баганы ул мөр илрээгүй тул сууцны ханыг өнгөн хөрсөн дээр шууд тавьж байсныг илтгэнэ. Тэгэхээр төмрийн түрүү үед хамаарагдах тус сууц (НТӨ 500/400 он) гэр эвсэл майхан загвартай, хөнгөн зөөврийн маягийн сууц байжээ. Эндээс олдсон ваарны хагархай дээр хийсэн химийн найрлагын шинжилгээг (Neutron Activation Analysis) хоёр хөндийн шаварны найрлагатай харьцуулан авч үзэхэд Тарвагатайн хөндийн энэ аманд байсан хүмүүсийн өдөр тутам хэрэглэдэг шавар савнуудаа зөвхөн Эгийн голын шавраар хийдэг байсан нь тогтоогдсон билээ (Gardner 2016). Үүнээс харвал Эгийн голын зүүн өмнөд хэсэгт явагдаж байсан нэгдэх үйл явц зөвхөн ёслолын үйл ажиллагаатай холбоотой бус ахуйн орчинд ч мөн нэгэн зэрэг явагдаж байжээ. Нэг талаас Тарвагатайн голын хөндийгөөс дөрвөлжин булш олдохгүй байгаа нь дэд бүс нутгийн хэмжээнд хаана, хэн (аль хөндийн бүлэг), ямар зан үйл үйлдэхээр бэлдэж байгаа талаарх мэдээлэл хангалттай солилцож байсныг харуулна. Нөгөө талаас шинэ төрлийн удирдлага, дэглэлт орж ирсэн байсан ч нүүдэлчид бие биетэйгээ харилцахдаа ахуйн зүйлс солилцох, нийгмийн харилцаанд бусад хэлбэрээр орох сонирхолтой хэвээр байжээ. Ямар нэгэн хориг, чиглүүлэг оролцсон энэ хэлбэр бол хоёр хөндийн хувьд цоо шинээр бүрэлдэж байсан хэлбэр бөгөөд дэд бүсийн ёслолын, нийгмийн, бэлэгдлийн төвийг нэгдэлтийн замаар үүсгэх үндсийг тавьсан байна. Энэ бүхнээс үзэхэд Монголын төв хэсгийн бусад газарт ч гэсэн үүнтэй төстэй үйл явц өрнөж байсан байх боломжтой юм. Цаашлаад орон нутгийн болон дэд бүсийн ийм бүлгүүд яваандаа НТӨ III зууны Хүннү төрийг үүсэн мандах зохион байгуулалтын үндсийг тавьсан бизээ.

## Дүгнэлт

Бидний санал болгосон нийгмийн нарийн зохион байгуулалтын эхэн үе шаттай холбоотой үйл явцыг авч үзвэл энэ бүхэн шилжилт хөдөлгөөний идэвхжилтээс эхэлсэн хэмээн таамаглав. Энэ таамаг ялангуяа уудам газар нутагт амьдарч байсан цөөн хүн амд нэн хамааралтай бөгөөд Эг ба Тарвагатайн голын хөндийн хувьд шилжилт хөдөлгөөн, хөндий хоорондын даваа, хөндийгөөс гарах болон хөндий рүү орох жим (зам) чухал үүрэг гүйцэтгэх болсныг дээрх хиргисүүрийн

судалгаа харуулж байна. Энэхүү шилжилт хөдөлгөөний идэвхжилтэнд чухал үүрэг гүйцэтгэсэн шинэ технологи бол энэ үеэс эхлэн адууг уналганд ашиглах болсон явдал юм (Taylor et al. 2018).

Монголын төв хэсгийг олон үеийн, соёлын уулзвар, нүүдэлчдийн төрийн үед “төв” газар байсан гэж үзсээр ирсэн билээ (Honeychurch, Amartuvshin 2011). Хоёр хөндийн нийгмийн үйл явц, өөрчлөлттэй холбоотой байдлыг газар зүйн үүднээс авч үзэхэд маш сонирхолтой үр дүн гарсан юм. Энэ нь тухайн үеийн Монголд өгүүлэн буй хоёр үед орших тогтож байсан баруун хойд ба зүүн өмнө хэсгийн соёлын нөхцөл байдал Монголын төв хойд хэсэгт хэрхэн тусгалаа олсныг орон зайн болон он цагийн шинжилгээгээр нягтлахад орон нутгийн хэмжээнд тольдсон мэт үр дүн гарсан. Нүүдэлтэй холбоотой амьдралын туршлага, мэдлэг, технологи нь хоёр хөндийн хүн ам дунд суух тусам харилцах хэлбэр, давтамжид өөрчлөлт орж хэдэн зууны турш нэгдмэл соёлын хүрээнд оршсон. Харин түрүү төмрийн үе болоход Эгийн голын зүүн өмнөд хэсгийн бүлэг зүүн өмнөд талаас орж ирж байсан шинэ заншилтай анх танилцаж ашиглах болсон нь тэдний гарт дэд бүсийн цаашдын хувь заяаг атгах боломжийг өгсөн байна.

Эцэст нь бид нийгмийн нарийн зохион байгуулалтын асуудал руу эргэн харах шаардлагатай байна. Энд дурдсан судалгааны үр дүнгүүдийг хэлэлцүүлэхдээ бид нийгмийн анги давхарга, төвлөрсөн засаглал, эд баялаг, хувийн өмч, нийгмийн байр суурь зэрэг нэр томьёонуудыг тэр бүр ашиглаагүйг анзаарсан байх. Эсрэгээрээ бид нийгмийн бүлэг бүрэлдэх үйл явц дээр илүү анхаарлаа хандуулахыг хичээв. Тэгвэл хэд хэдэн жижиг бүлэг нэгдэн нэг том бүлэг үүсгэсэн нь яагаад нийгмийн нарийн зохион байгуулалт болоод байгаа асуулт урган гарч ирнэ. Археологийн судалгаагаар гаргаж ирсэн энэ бүлэг хэд хэдэн хэсгээс бүрдэж байна. Үүнд, нэгж айл, уулын салаа амуудын жижиг бүлэг, нэг голын хөндийн бүлэг багтана. Хэд хэдэн бүлгийн төрөлд хамаарагдаж байгаа нүүдэлчин хүн тус бүрт тохирсон эсвэл шаардагдсан харилцааны хэлбэрийг ашиглаж өөрт байгаа зүйлээ өгч, хэрэгтэй зүйлээ эргүүлэн авдаг байжээ.

НТӨ 800 оны үед хэд хэдэн хөндийн хүн амаас бүрдсэн шинэ бүлгийн хэлбэрт эхэлжээ. Үүний үр дүнд дөрвөлжин булшийг хаана барьж болох, болохгүйг заасан тэнцвэрт бус тогтолцоо бий болсныг бид өмнө нь дурдсан. Хэдийгээр нэг нийгмийн бүлэгт харьяалагдаж байгаа гэсэн сэтгэгдэл хүн бүрт байсан боловч харилцааны түвшний хувьд тэгш бус байдал яваандаа урган гарчээ. Тухайлбал, төмрийн түрүү үед Эгийн голын зүүн өмнөд хэсэгт амьдардаг хүн “захын” Тарвагатайн голын хөндийн хүнтэй харьцахдаа илүү эрхтэй байдлыг мэдэрч байсан байх тун боломжтой юм.

Тиймээс нийгмийн нарийн зохион байгуулалтыг тодорхойлолтонд оруулж зааглах бус харин бидний санал болгож буй нийгмийн үйл явц талаас нь авч үзвэл илүү оновчтой хэмээн үзэж байна. Нийгмийг зөвхөн хэлбэр (ангит, тэгш эрхт гэх мэт) талаас нь биш харин үйл явц (нэгдэл, задрал, эсэргүүцэх, хүлээн зөвшөөрөх гэх мэт) талаас нь авч үзвэл бид тухайн нийгмийн гүн рүү нэвтрэх боломж бий болох бөгөөд ийм хандлага археологийн судалгаанд нэвтрээгүй байгаа цагт бид өмнөх үеийн нийгмүүдийг тодорхойлох, харьцуулахаас илүү үр дүнд хүрэхгүй болов уу.

### Abstract

## ARCHAEOLOGICAL ANALYSIS OF SOCIAL COMPLEXITY OF EARLY PASTORAL NOMADS

by Burentogtokh Jargalan and William Gardner

The issue regarding social complexity among pastoral nomads has been a long-lasting puzzle for historian, anthropologists, and archaeologists. Such problems arises from the approach to look at past nomadic societies through narrow ecological and economic lenses. Even the concept of “social complexity” among archaeologists is problematic. Initially derived from system theories and political economy, the definition of social complexity places heavy emphasis on social stratification, industrialized economies, and centralized governance of sedentary societies. We argue that such approach to social complexity is not suitable to explain stages of social complexity among pastoral nomads. This is why we are introducing a different approach that considers integration, scale, and mobility. By explaining initial stages of social complexity of early pastoral communities in the case of two neighboring valleys in north central Mongolia, we can begin to understand how one of the first states in eastern Eurasian steppe emerged at the end of the 1st millennium BCE.

**Keywords:** Archaeology of nomads, social complexity, social process

### Ном зүй

Burentogtokh, J. (2017). Pastoralists, communities, and monumentality during the Mongolian Bronze Age. Yale University.

Chang, C. (2018). Rethinking prehistoric Central Asia. Routledge.

Gardner, W. (2016). Early political complexity and community organization on the Mongolian steppe. Yale

University.

Gardner, W., Burentogtokh, J. (2018). Mobile domiciles of the Eurasian steppe: archaeological evidence of possible dwelling space during the Early Iron Age. *Journal of Field Archaeology*.

Honeychurch, W. (2015). Inner Asia and the spatial politics of empire: archaeology, mobility, and cultural contact. Springer.

Honeychurch, W., Amartuvshin, C. (2011). Timescapes from the past: an archaeogeography of Mongolia. In P. Sabloff (Ed.), *Mapping Mongolia: situating Mongolia in the World from geologic time to the present* (pp. 195–219). University of Pennsylvania Press.

Honeychurch, W., Wright, J., Amartuvshin, C. (2009). Re-writing monumental landscape as Inner Asian political process. In B. Hanks, K. Linduff (Eds.), *Social complexity in prehistoric Eurasia: monuments, metals, and mobility*. (pp. 330–357). Cambridge University Press.

Kradin, N. (2006). Cultural complexity of pastoral nomads. *World Cultures*, 15(2), 171–189.

Kradin, N. (2018). Ancient steppe nomad societies. In D. Ludden (Ed.), *Oxford research encyclopedia of Asian history* (pp. 1–28). Oxford University Press.

Littleton, J., Floyd, B., Frohlich, B., Dickson, M., Amgalantugs, T., Karstens, S., Pearlstein, K. (2012). Taphonomic analysis of Bronze Age burials in Mongolian khirigsuurs. *Journal of Archaeological Science*, 39, 3361–3370.

Orlando, L. (2018). Late Bronze Age cultural origins of dairy pastoralism in Mongolia. *Proceedings of the National Academy of Sciences*, 115(48), 12083–12085.

Taylor, W. (2017). Horse demography and use in Bronze Age Mongolia. *Quaternary International*, 270–282. Taylor, W., Bayarsaikhan, J., Tuvshinjargal, T., Bender, S., Tromp, S., Clark, J., Lowry, K., Houle, J.-L., Staszewski, D., Whitworth, J., Fitzhugh, W., Boivin, N. (2018). Origins of equine dentistry. *Proceedings of the National Academy of Sciences*, 115(29), 6707–6715.

Галдан, Г. (2015). Эртний нүүдэлчдийн бууц суурин (отог)-ийн судалгаа. - *Studia Archaeologica*, Том. 35, Fasc. 13., 184–197.

Жаргалан, Б. (2022). Нүүдэлчид: археологи, нийгэм, аж ахуй. Соёмбо Пресс.

Жаргалан, Б., Гарднер, У. (2018). Эртний нүүдэлчдийн оромж илрүүлэх маллагын болон шинжилгээний арга зүй. - *Studia Archaeologica*, Том. 38, Fasc. 14, 55–166.

